



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/151/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв
 - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.01.28 № УВА-2026/151/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР
ЗӨВЛӨХ Д.ГАЛБАДРАХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050051

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,055,995.00</u>	<u>34,090,709.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	31,055,995.00	34,090,709.00
354	Хангамжийн материал	31,055,995.00	34,090,709.00
35420	Аж ахуйн материал	26,812,365.00	29,982,379.00
35440	Түлш, шатах тослох материал	608,900.00	473,600.00
35470	Бусад хангамжийн материал	3,634,730.00	3,634,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,375,176,177.77</u>	<u>3,500,385,537.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,375,176,177.77	3,500,385,537.83
392	Биет хөрөнгө	3,329,566,177.77	3,455,105,537.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,255,982,380.00	3,255,523,270.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-122,870,087.51	-180,042,251.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,000,000.00	225,634,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-106,541,666.60	-19,708,933.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	142,824,841.00	155,837,511.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,572,385.72	-57,666,355.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,508,995.47	118,508,995.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,765,898.87	-42,980,698.03
393	Биет бус хөрөнгө	45,610,000.00	45,280,000.00
39301	Програм хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-660,000.00	-990,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,950,000.00	44,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,406,232,172.77</u>	<u>3,534,476,246.83</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,406,232,172.77</u>	<u>3,534,476,246.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,406,232,172.77	3,534,476,246.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,038,414.75	212,038,414.75
51101	Өмч: - төрийн	212,038,414.75	212,038,414.75
512	Хуримтлагдсан үр дүн	2,964,013,637.74	3,092,716,821.80
51210	Өмнөх үеийн үр дүн	2,964,013,637.74	2,964,472,747.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	128,244,074.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,180,120.28	229,721,010.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,406,232,172.77</u>	<u>3,534,476,246.83</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,315,670,493.00	1,892,909,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,663,093.00	239,382,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,663,093.00	239,382,700.00
	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,336,397.00	239,382,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	46,336,397.00	239,382,700.00

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	11,326,696.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,258,007,400.00	1,653,526,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,255,607,400.00	1,621,926,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,255,607,400.00	1,621,926,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,400,000.00	31,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,400,000.00	31,600,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,385,945,362.63	1,754,914,925.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,945,362.63	1,754,914,925.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,324,843,621.33	1,615,106,060.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	935,026,485.06	1,183,073,494.59
210101	Үндсэн цалин	532,669,108.22	710,071,484.07
210102	Нэмэгдэл	266,366,754.84	359,660,293.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,121,000.00	60,449,311.44
210104	Урамшуулал	74,869,622.00	52,892,405.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,917,569.30	149,675,506.23
210201	Тэтгэврийн даатгал	79,738,489.32	101,647,554.71
210202	Тэтгэмжийн даатгал	9,380,998.80	11,958,535.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,888,121.60	6,259,932.25
210204	Ажилгүйдлийн даатгал	4,582,162.78	5,959,996.17
210205	Эрүүл мэндийн даатгал	18,327,796.80	23,849,487.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,994,209.64	86,595,730.09
210301	Гэрэл, цахилгаан	4,940,483.04	6,465,624.09
210302	Түлш, халаалт	50,487,575.60	73,161,968.00
210303	Цэвэр, бохир ус	6,566,151.00	6,968,138.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,408,620.70	49,701,942.00
210401	Бичиг хэрэг	16,705,700.00	15,269,750.00
210402	Тээвэр, шатахуун	15,124,034.00	16,647,164.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,881,793.70	4,244,056.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,150.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,276,943.00	13,020,972.00
2105	Нормативт зардал	0.00	486,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	486,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,310,000.00	9,071,900.00
210604	Урсгал засвар	9,310,000.00	9,071,900.00
2107	Томилолт, зочны зардал	7,308,050.00	5,366,000.00
210702	Дотоод албан томилолт	7,308,050.00	5,366,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,651,953.00	2,144,138.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,300,000.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,638.00	158,838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	587,315.00	587,300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,226,733.63	128,991,349.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,730,766.00	2,000,000.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,102,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,393,967.63	126,991,349.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,101,741.30	139,808,865.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,820,000.00	47,237,497.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	26,675,497.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	20,562,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,820,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,281,741.30	92,571,368.09
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,281,741.30	92,571,368.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-70,274,869.63	137,994,074.06
	Үйл ажиллагааны бус зардлын дүн	0.00	9,750,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал /Үндсэн хөрөнгө/	0.00	9,750,000.00
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.00	-9,750,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-70,274,869.63	128,244,074.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,258,007,400.00	1,653,526,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,258,007,400.00	1,653,526,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,255,607,400.00	1,621,926,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,255,607,400.00	1,621,926,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,400,000.00	31,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,400,000.00	31,600,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,254,256,000.00	1,630,958,290.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,254,256,000.00	1,630,958,290.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,193,154,258.70	1,491,149,424.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	935,026,485.06	1,183,073,494.59
210101	Үндсэн цалин	533,438,936.69	710,861,964.30
210102	Нэмэгдэл	266,092,910.84	359,094,694.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,625,015.53	60,224,430.63
210104	Урамшуулал	74,869,622.00	52,892,405.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,917,569.30	149,675,506.23
210201	Тэтгэврийн даатгал	79,738,489.32	101,647,554.71
210202	Тэтгэмжийн даатгал	9,380,998.80	11,958,535.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,888,121.60	6,259,932.25
210204	Ажилгүйдлийн даатгал	4,582,162.78	5,959,996.17
210205	Эрүүл мэндийн даатгал	18,327,796.80	23,849,487.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,994,209.64	86,595,730.09
210301	Гэрэл, цахилгаан	4,940,483.04	5,954,666.09

210302	Түлш, халаалт	50,487,575.60	73,161,968.00
210303	Цэвэр, бохир ус	6,566,151.00	7,479,096.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,150,191.70	43,638,366.00
210401	Бичиг хэрэг	9,855,700.00	8,705,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,489,334.00	16,511,864.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,881,793.70	4,244,056.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	633,550.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,289,814.00	13,656,546.00
2105	Нормативт зардал	00.00	486,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	486,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,310,000.00	11,203,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,031,990.00
210604	Урсгал засвар	9,310,000.00	10,171,900.00
2107	Томилолт, зочны зардал	7,308,050.00	5,366,000.00
210702	Дотоод албан томилолт	7,308,050.00	5,366,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,751,953.00	9,110,438.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,400,000.00	7,766,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,638.00	158,838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	587,315.00	587,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,695,800.00	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,593,800.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,101,741.30	139,808,865.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,820,000.00	47,237,497.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,675,497.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	20,562,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,820,000.00	00.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,281,741.30	92,571,368.09
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,281,741.30	92,571,368.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,751,400.00	22,568,010.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,751,400.00	22,568,010.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,751,400.00	22,568,010.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,751,400.00	22,568,010.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,751,400.00	22,568,010.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,751,400.00	-22,568,010.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,038,414.75	230,180,120.28	2,964,013,637.74	00.00	3,406,232,172.77
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,038,414.75	230,180,120.28	2,964,013,637.74	00.00	3,406,232,172.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	459,110.00	00.00	459,110.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,038,414.75	230,180,120.28	2,964,472,747.74	00.00	3,406,691,282.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-459,110.00	00.00	00.00	-459,110.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	128,244,074.06	00.00	128,244,074.06
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,038,414.75	229,721,010.28	3,092,716,821.80	00.00	3,534,476,246.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,627,994,300.00	1,529,354,931.91	98,639,368.09	93.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,627,994,300.00	1,529,354,931.91	98,639,368.09	93.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,574,688,800.00	1,482,117,434.91	92,571,365.09	94.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,255,319,000.00	1,183,073,494.59	72,245,505.41	94.2
Үндсэн цалин	654,835,300.00	710,861,964.30	(56,026,664.30)	108.6
Нэмэгдэл	419,424,600.00	359,094,694.16	60,329,905.84	85.6
Унаа хоолны хөнгөлөлт	72,358,000.00	60,224,430.63	12,133,569.37	83.2
Урамшуулал	108,701,100.00	52,892,405.50	55,808,694.50	48.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,694,100.00	149,675,506.23	16,018,593.77	90.3
Тэтгэврийн даатгал	112,667,600.00	101,647,554.71	11,020,045.29	90.2
Тэтгэмжийн даатгал	13,255,000.00	11,958,535.85	1,296,464.15	90.2
ҮОМШӨ-ний даатгал	6,637,900.00	6,259,932.25	377,967.75	94.3
Ажилгүйдлийн даатгал	6,626,800.00	5,959,996.17	666,803.83	89.9
Эрүүл мэндийн даатгал	26,506,800.00	23,849,487.25	2,657,312.75	90.0

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,678,400.00	86,595,730.09	1,082,669.91	98.8
Гэрэл, цахилгаан	13,392,100.00	5,954,666.09	7,437,433.91	44.5
Түлш, халаалт	67,734,400.00	73,161,968.00	(5,427,568.00)	108.0
Цэвэр, бохир ус	6,551,900.00	7,479,096.00	(927,196.00)	114.2
Хангамж, бараа материалын зардал	42,682,700.00	39,638,366.00	3,044,334.00	92.9
Бичиг хэрэг	13,978,300.00	8,705,900.00	5,272,400.00	62.3
Тээвэр, шатахуун	12,834,300.00	12,511,864.00	322,436.00	97.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,385,300.00	4,244,056.00	3,141,244.00	57.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	797,200.00	520,000.00	277,200.00	65.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,687,600.00	13,656,546.00	(5,968,946.00)	177.6
Нормативт зардал	486,000.00	486,000.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	486,000.00	486,000.00	0.00	100.0
Эд хогшил, худалдан авах	6,198,000.00	6,171,900.00	26,100.00	99.6
Урсгал засвар	6,198,000.00	6,171,900.00	26,100.00	99.6
Томилолт, зочны зардал	5,390,000.00	5,366,000.00	24,000.00	99.6
Дотоод албан томилолт	5,390,000.00	5,366,000.00	24,000.00	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,240,600.00	9,110,438.00	130,162.00	98.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,766,400.00	7,766,300.00	100.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	267,000.00	158,838.00	108,162.00	59.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,900.00	22,000.00	21,900.00	50.1
Газрын төлбөр	587,300.00	587,300.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
Урсгал шилжүүлэг	53,305,500.00	47,237,497.00	6,068,003.00	88.6
Бусад урсгал шилжүүлэг	53,305,500.00	47,237,497.00	6,068,003.00	88.6
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,675,500.00	26,675,497.00	3.00	100.0
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	20,562,000.00	20,562,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,068,000.00	0.00	6,068,000.00	0.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,621,926,400.00	1,621,926,300.00	100.00	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,621,926,400.00	1,621,926,300.00	100.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,621,926,400.00	1,621,926,300.00	100.00	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,600,000.00	(31,600,000.00)	
УРСГАЛ ЗАРДАЛ		31,600,000.00	(31,600,000.00)	
Бараа үйлчилгээний зардал		31,600,000.00	(31,600,000.00)	
Хангамж, бараа материалын зардал		4,000,000.00	(4,000,000.00)	
Тээвэр, шатахуун		4,000,000.00	(4,000,000.00)	
Эд хогшил, урсгал засварын зардал		27,600,000.00	(27,600,000.00)	
Багаж, техник, хэрэгсэл		13,600,000.00	(13,600,000.00)	
Тавилга		10,000,000.00	(10,000,000.00)	
Урсгал засвар		4,000,000.00	(4,000,000.00)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		31,600,000.00	(31,600,000.00)	
Нэмэлт санхүүжилтийн орлого		31,600,000.00	(31,600,000.00)	
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		31,600,000.00	(31,600,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Прокурорын газар нь Монгол улсын нутаг дэвсгэрт Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, хүний нөөцийг чадархжуулах, дээд шатны прокурорын манлайлал, үүрэг хариуцлагыг сайжруулах, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чанар, үр нөлөөг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгал болон татварын тухай хууль, Прокурорын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,

- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн байна.

Увс аймгийн Прокурорын газар нь Прокурорын ерөнхий газрын даргын 2021 оны 179 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 128,244.0 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	0	0
Урьдчилгаа			
Бараа материал	31,056.0	34,090.7	3,034.7
Үндсэн хөрөнгө	3,375,176.2	3,500,385.5	125,209.3
Нийт хөрөнгө	3,406,232.2	3,534,476.2	128,244.0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,406,232.2	3,534,476.2	128,244.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,406,232.0	3,534,476.2	128,244.0

Мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, урьдчилж гарсан зардлын эхний болон эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,090.7 мянган төгрөг болж 3,034.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 54,611.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 51,576.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Энэ нь аж ахуйн материал дансны эцсийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,500,385.5 мянган төгрөг болж 125,209.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 22,568.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч, Прокурорын ерөнхий газраас 233,504.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан ба дахин үнэлгээний нэмэгдэл 5,878.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, данс бүртгэлээс 7,673.6 мянган төгрөгийн хөрөнгө хасч, 117,000.0 мянган төгрөгийн авто, тээврийн хэрэгсэл шилжүүлсэнтэй холбоотой байна .

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,534,476.2 мянган төгрөг болж 128,244.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 577,238.5 мянган төгрөгөөр буюу 43.9 хувиар өссөн байна. Орлого өсөхөд үндсэн цалин нэмэгдсэн болон үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 368,969.5 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна. Зарлага өсөхөд үндсэн цалин, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал шилжүүлэг нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,705,979.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг 1,705,979.8 мянган төгрөгөөр баталсныг, төсвийн тодотголоор 77,985.5 мянган төгрөгөөр бууруулж 1,627,994.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн хэмнэлт үүсгэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 77,985.5 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,627,994.3 мянган төгрөгийг улсын төсвөөс орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,621,926.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож үйл ажиллагаагаа явуулсан ба нийт 92,571.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,529,354.9 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг хэмнэж 92,571.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн болон ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 6,068.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,566,922.4	1,474,351.0	92,571.4	94.1 %
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	53,305.5	47,237.4	6,068.1	88.6%
3	Байцаан шийтгэх ажиллагаа	7,766.4	7,766.4	0.0	100.0%
	Нийт	1,627,994.3	1,529,354.9	98,639.5	93.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	1,320.0	Acoluos, Payroll
2	Унаа, хоолны зардал	60,224.4	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 12.0 мянга, унааны хөнгөлөлт 1.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	0.0	Төсвийн хөрөнгөөр сургалтын зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	800.0	Тайлант онд "Сама-Увс" телевизтэй 800.0 мянган төгрөгөөр хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Увс аймгийн Прокурорын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 31,600.0 мянган төгрөгийн орлого бүрджээ.

Гүйцэтгэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, албан конторт буйдан, ширээ, засвар үйлчилгээ хийх арга хэмжээнд 31,600.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Прокурорын газар нь 2025 онд цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин 22,568.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 51,611.5 мянган төгрөгийн бараа материалыг тайлант онд шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,385,945.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,859.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,087.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,754,914.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 17,549.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 14,039.3 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Прокурорын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Дүн											
Нийт дүн											

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр